

БНАСАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР*Д.Начин**

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд БНАСАУ-ын эдийн засгийн дэлхийн болон Зуун хойд Азийн эдийн засагт эзлэх байр, суулийн арван жилийн хугацаанд жилд дунджаар 2 хувийн өсөлттэй байгаа, цаг агаарын болон улс төрийн бодлогоос ихээхэн хамаарч байдаг тухай өгүүлсэн байна.

Солонгосын дайны дараа сэргээн босголтын ажил эрчимтэй өрнүүлж, социалист орнуудын их хэмжээний тусламжийн үр дүнд 1960-аад он гэхэд БНАСАУ-д дайны сүйрлийг үндсэнд нь сэргээн босгожээ.

БНАСАУ-ын эдийн засаг 1970-1980-аад оны дунд үе хүртэл нэлээд өсөлттэй явж, 1980-аад оны сүүлчээс буурах хандлагатай болсон, 1990-ээд оноос эдийн засгийн гол түнш болох ЗХУ болон социалист систем задарсантай холбогдож, эрчим хүч, түүхий эдийн хомсдолын улмаас үйлдвэр, аж ахуйн газрууд зогсож, үр тарианы үйлдвэрлэл буурсан. 1990-ээд он бол БНАСАУ-ын хувьд ч эдийн засгийн хямралтай хүнд үе байв.

БНАСАУ-ын улс төр, үзэл сурталын өвөрмөц бодлого (1960-аад оноос баримталж ирсэн Чучхе - бие даах үзэл суртал, 1990-ээд оны дундаас Ким Жөн Иррийн санаачлан хэрэгжүүлж буй “Цэрэг арми тэргүүлсэн бодлого”, эдийн засгийн хувьд “Хүчирхэг гүрэн байгуулах” зорилт нь улсын төсвийн 20 шахам хувийг батлан хамгаалах салбарт зарцуулж буй) нь үйлдвэрлэлээ сэргээн хөгжүүлэхэд гадны тусламж, дэмжлэг авах, хамтын ажиллагаанаас татгалзахад хүргэж байв.

БНАСАУ-ын (ДНБ 26,2 тэрбум ам.доллар) эдийн засгийн хэмжээ чадавхаар дэлхийн улс орнуудтай харьцуулахад дунд зэрэгт орж, нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээгээр 191-д бичигдэж байна. Харин ДНБ-ий өсөлт 2007 онд -2,3% (213) байв.¹

БНАСАУ-ын Зүүн хойд Азийн орнуудын нийт эдийн засагт оруулж буй хувь хэмжээ 0,22%-тай тэнцүү байхад Япон ЗХА-ийн орнуудын ДНБ-ий 41,36%-ийг, БНХАУ 36,05%-ийг, ОХУ 15%-ийг, БНСУ 7,32%-ийг, Монгол Улс 0,043%-ийг тус тус бий болгож байна.

Ихэнх шинжээчид Умард Солонгосын эдийн засаг гүн хямралаас гарахгүй, жил тутам агшиж байгаа тухай дүгнэлт хийдэг боловч БНАСАУ-ын ДНБ-ий сүүлийн 10 жилийн өөрчлөлтийг авч үзвэл 2006, 2007 онд л бууралттай байгаагаас биш жилд дундажаар 2,0-иар өссөн байна.

* Д.Начин - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ажилтан

Хүснэгт 1. БНАСАУ-ын ДНБ-ий өөрчлөлт, хувиар

Он	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
ДНБ-ий өөрчлөлт, %	6,2	1,3	3,7	1,2	1,8	2,2	3,8	-1,1	-2,3	3,7

Эх сурвалж: Bank of Korea “GDP of North Korea”

БНАСАУ-ын ДНБ-ий 2008 оны 3,7%-ийн өсөлтийг цаг агаарын тааламжтай нөхцлийн улмаас ХАА-н салбарын өсөлт болон 6 талт хэлэлцээний дагуу нийлүүлсэн түүхий эд, түүхий нефть мазуттай холбон үзэж байна.

Хүснэгт 2. БНАСАУ-ын ДНБ-ий салбарын өөрчлөлт, хувиар

Салбар	2006	2007	2008
ХАА, ой, загас агнуурын салбарын ДНБ дэх өөрчлөлт, %	-2,6	-9,4	8,2
Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ дэх өөрчлөлт, %, үүнээс	0,9	0,7	2,5
- Уул уурхай	1,9	0,4	2,3
- Боловсруулах үйлдвэрлэл, үүнээс	0,4	0,8	2,5
- Хөнгөн үйлдвэр	-0,6	-1,7	1,3
- Хүнд үйлдвэр	1,1	2,3	3,3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамж	2,7	4,8	6,1
Барилгын үйлдвэрлэл	-11,5	-1,5	1,1
Үйлчилгээний салбар	1,1	1,7	0,7
- Засгийн газрын	0,8	1,8	0,3
- Бусад үйлчилгээ	1,8	1,5	1,7
ДНБ-ий өсөлт	-1,1	-2,3	3,7

ХАА,² ой, загас агнуурын салбарын ДНБ-ий өсөлт 2008 онд 8,2 байгааг ерөнхийд нь цаг агаарын тааламжтай нөхцөлтэй л холбохоос өөр аргагүй, (тариалах талбай, байгалийн баялгийн нөөц хязгаарлагдмал, тэгээд ч ой, загас агнуурын бүтээгдэхүүний Японд хийх экспорт хумигдсан).

Харин уул уурхайн салбар³-ын 2,3 хувийн өсөлтийг нүүрс, металл болон металл бус эрдэсийн олзворлолтыг хэрэгцээ (Хятадын импортын) нь өсөн нэмэгдэж байгаатай уялдан нэмэгджээ.

Хөнгөн үйлдвэрийн салбарын 1,3%-ийн өсөлт хүнс, тамхи, гутал, хувцасны үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой.

Хүнд үйлдвэрийн өсөлт өмнөх 2007 оныхоос их 3,3 хувь байгаа нь тухайн салбарт анхаарч үндсэн металл, химийн бодис, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэнээс болжээ.

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамж 6,1 хувиар өссөн нь дулааны болон усан цахилгаан станцын үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой аж.

Иргэдийн орон сууц барих, иргэний барилга байгууламж нэмэгдсэнтэй холбогдон барилгын салбарт 1,1 хувийн өсөлт гарав.

Үйлчилгээний салбарын өсөлт дөнгөж 0,7 хувь байгааг зочид буудал, рестораны үйлчилгээ 2,2 хувиар буурсантай, тухайлбал, 2008 оны 6 дугаар сард Кымгансан ууланд Өмнөд Солонгосын жуулчинг буудсан хэрэг явдалтай шууд холбоотой.

2006-2008 онд БНАСАУ-ын ДНБ-ий 43,1-46,2 хувийг аж үйлдвэр, 23,3- 21,2-23,3 хувийг хөдөө аж ахуй, 32,2-34,1 хувийг үйлчилгээний салбар тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 3. БНАСАУ-ын ДНБ-ий салбарын бүрдүүлэлт, хувиар

	2006	2007	2008
ХАА, ой, загас агнуурын салбар	23,3	21,2	21,6
Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, үүнээс	29,6	31,3	34,6
- Уул уурхай	10,2	11,4	12,1
- Боловсруулах үйлдвэрлэл, үүнээс	19,5	20,0	22,5
- Хөнгөн үйлдвэр	6,7	6,5	6,7
- Хүнд үйлдвэр	12,8	13,5	15,8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамж	4,5	4,6	3,4
Барилгын үйлдэрлэл	9,0	8,8	8,3
Үйлчилгээний салбар	33,6	34,1	32,2
- Засгийн газрын	23,7	24,0	22,8
- Бусад үйлчилгээ	9,8	10,1	9,4
ДНБ	100,0	100,0	100,0

2008 онд БНАСАУ-ын ДНБ-д ХАА, ой, загас агнуурын, уул уурхай, боловсруулах үйлдвэрийн салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн байхад Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамж, Барилгын үйлдвэрлэл, Үйлчилгээний салбарын хувь хэмжээ буурсан байна.

ДНБ-д ХАА, ой, загас агнуурын салбарын эзлэх хувь хэмжээ нь байгалийн баялаг, тариалалтын талбай хязгаарлагдмал, цаг уурын эрсдэлтэй учир нэмэгдээд байх бололцоогүй, харин бусад салбарын хувь хэмжээ багасвал харьцангуй нэмэгдэж болох талтай.

Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь тус салбарын дотоодын болон гадаадын (үндсэндээ Хятадын) хэрэгцээгээр тодорхойлогдож ойрын жилүүдэд нэмэгдэх төлөвтэй байна.

Хүнд үйлдвэрийн салбарыг тэргүүлэх чиглэл болгосон учир энэ салбарын ДНБ-д эзлэх хувь нэмэгдэх магадлалтай.

Хүнсний хэрэгцээг өөрсдөө хангах, хүн амын өргөн хэрэглээний үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилт тавьж байгаа тул Хөнгөн үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь мөн өсөх болов уу. 2009 оны 7 дугаар сард БНАСАУ-ын АДХТ-ийн тогтоолоор Хүнс, хүн амын өдөр тутмын барааны үйлдвэрийн яамыг шинээр байгуулах шийдвэр гаргасан.

Хүснэгт 4. БНАСАУ-ын эдийн засгийн гол үзүүлэлтүүд 2008 он

Үзүүлэлт	Тоо хэмжээ
1. Хүн ам, сая хүн	24,0
2. ДНБ-ий өсөлт, %	3,7
3. ҮНБ, тэрбум вон	27 347,2
4. Нэг хүнд оногдох ҮНБ, сая вон	1,17
5. Гадаад худалдаа, сая ам.доллар	
Нийт эргэлт	3820
Экспорт	1130
Импорт	2690
Ханш =1 ам.доллар	130
6. Эрчим хүч	
Нүүрс үйлдвэрлэл, сая тонн	2,5
Цахилгаан станцуудын хүчин чадал, МВт	7497
Цахилгааны үйлдвэрлэл, сая кВтцаг	25 460
Түүхий нефтийн импорт, сая баррель	3,8
7. Хөдөө аж ахуй, загас далайн бүтээгдэхүүн	
Үр тариа, сая тонн	4,3
Цагаан будаа, сая тонн	1,8
Загас, далайн бүтээгдэхүүн, сая тонн	0,8
8. Уул уурхайн бүтээгдэхүүн	
Төмрийн хүдэр, сая тонн	5,3
Өнгөт металл, мянган тонн	94
9. Үйлдвэрийн бүтээгдэхүүн	
Автомашин, мянган нэгж	4,7
Ган, сая тонн	1,3
Цемент, сая тонн	6,4
Бордоо, сая тонн	0,4
Нийлэг утас, мянган тонн	30
10. Дэд бүтэц	
Төмөр замын урт, км	5 242
Замын урт, км	25 802
Боомтын ачих/буулгах чадал, сая тонн	37
Хөлөг онгоцны багтаамж, мянган тонн	860

Эх сурвалж: Bank of Korea “GDP of North Korea”

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамжийн хувьд дулааны болон усан цахилгаан станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилт тавьсан. БНАСАУ-ын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг Хүснэгт 4-өөс үзнэ үү. 100 мянган айлын орон сууц төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхээр ажиллаж буй. Аялал жуулчлалыг сэргээх, ялангуяа Өмнөд Солонгосын жуулчдыг нэмэгдүүлэх талд сүүлийн үед их анхаарч байна.

ДҮГНЭЛТ

БНАСАУ-ын эдийн засаг нь өнөөг хүртэл улс төрийн бодлого, олон улсын байдал, цаг агаарын нөхцлөөс ихээхэн хамаарч ирсэн, түүнчлэн цөмийн болон пуужингийн туршилт хийсэнтэй нь холбогдуулан олон улсын хамтын нийгэмлэгээс Умард Солонгосын эсрэг авсан арга хэмжээг чангаруулж байгаатай холбогдож 2009 онд тус улсын эдийн засгийн өсөлт буурсан үзүүлэлттэй гарахаар байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook>
2. Хөдөө аж ахуйг мал аж ахуйтай хослуулан хөгжүүлж хөдөө орон нутгийн аж ахуйн чиглэлийг нэмэгдүүлэх, байгалийн гаралтай бордоогоор хангах ажлыг эхлүүлэх зорилт тавин ажиллаж буй.

Хүснэгт БНАСАУ-ын малын тоо толгой

	2004	2008
Үхэр, мянган толгой	566	576
Гахай, мянган толгой	3 194	2 178
Хонь, мянган толгой	171	167
Ямаа, мянган толгой	2 736	3 441
Туулай, мянган толгой	19 677	26 467
Тахиа, мянган толгой	18 729	14 071
Нугас, мянган толгой	5 189	5 878
Галуу, мянган толгой	1 580	1 477

Хоршооллуудад газар тариалангийн тоног төхөөрөмж, трактор хүрэлцээгүй, төлөвлөсөн хэмжээнд бензин түлш авах (50-70 хувийг л авдаг) боломжгүй учир тариалангийн талбайн ачилга, зүтгүүрийн эр үхрийн тоог нэмэгдүүлж 1 га-д 2 эр үхэр байлгах зорилт тавин ажиллаж байгаа аж. Одоогийн байдлаар улсын хэмжээнд дунджаар 1 га-д 3 эр үхэр ногддог байна. БНАСАУ-ын газар нутгийн 80 хувийг уулархаг газар эзэлдэг учир үлдэх багахан хэсэгт буюу 2 сая орчим га-д газар тариалан эрхлэх боломжтой. Хүнсний зориулалтын үр тариаг 1,2-1,4 сая га-д тариалдаг.

3. БНАСАУ нь нүүрс, төмрийн хүдэр, шохойн чулуу, магнезит, цинк, хар тугалга, вольфрам, молибден, зэс, алт, жонш зэрэг байгалийн эрдэсийн баялагтай бөгөөд ойрын жилүүдэд нүүрс, төмрийн хүдэр, шохойн чулуу, магнезит, цинкийн үйлдвэрлэл голлох төлөвтэй байна.

БНАСАУ нь магнезитийн (хүдрийн нөөц 3,6 тэрбум тонн) олборлолтоор дэлхийд гуравт ордог бөгөөд түүний нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болох магнезиа-клинкер дэлхийн зах зээлд нилээд (1 сая орчим тонн) хэмжээгээр гаргадаг.

БНАСАУ-ын нүүрсний батлагдсан нөөцийг 2006 оны байдлаар 8 тэрбум тонноор үнэлж байв. 1985 онд 37,5 сая тонн нүүрс олборлож байснаа уул уурхайн тоног төхөөрөмж хуучирсан, хоцрогдсон технологиос шалтгаалан 2006 онд 23 сая тонн болж нүүрс олборлолтын хэмжээ буурсан.